

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэл Өмчит Улаанбаатар Хөрөнгө Оруулалтын менежмент ҮЦК ХХК-ийн 2024
оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/065/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

НТАГ-ын Дэд дарга: Ч.Болд
Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn

СНАХ-ийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayrkh@audit.gov.mn

Менежер: С.Гантөгс
Утас: 315558 Цахим хаяг: gantuguss@audit.gov.mn

“Си Эс Ай аудит” ХХК-ийн захирал: М.Сэвжидмаа
Утас: 19001981. Цахим хаяг: sieve@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Албан шаардлага	19
5.2 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЗК	Тусгай зориулалтын компани
ҮЦК	Үнэт цаасны компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025. 03. 14 № 61/252
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
УЛААНБААТАР ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ, МЕНЕЖМЖНТ ҮЦК
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ГАНГАМӨРӨН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн хөгжлийн сан хувийн ХОС /хөрөнгө оруулалтын сан/ ТЗК түүнийг төлөөлж Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт менежментийн ҮЦК нь Бөөрөлжүүтийн цахилгаан станцын бүтээн байгуулалтад зориулж гаргасан гурван мянган ширхэг, нэг зуун сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, гурван зуун тэрбум төгрөгийн 36 сарын хугацаатай, жилийн 14.44 хувийн хүүтэй бондыг худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

Нийслэлийн засаг даргын тамгын газрын Нийслэлийн хөгжлийн сан хувийн ХОС ТЗК-ийн сангийн гурван мянган ширхэг нэгж эрхийг гурван зуун тэрбум төгрөгөөр худалдан авч, дүрмийн санг гурван зуун тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 05/04 дугаар тогтоолоор нийт орлого 1,791.3 сая төгрөг, нийт зардал 1,788.2 сая төгрөг, цэвэр ашиг 3.0 сая төгрөг

гүйцэтгэлээр үнэт цаасны арилжааны цэвэр орлогоос 23,216.1 сая төгрөг, хүүгийн орлогоос 817.7 сая төгрөг, бусад орлогоос 800.3 сая төгрөг, нийт 24,834.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, нийт 23,225.4 сая төгрөгийг зарцуулж, 1,500.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилго, 13 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	10,981,828,755.44	9,448,038,064.06
1.1.2	Дансны авлага	225,448,837.04	1,362,436,556.95
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	3,125,652.05	7,005,209.98
1.1.4	Бусад авлага	-	2,571,515.42
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	500,000,000.00	2,450,000,000.18
1.1.6	Бараа материал	25,357,865.00	4,427,575.66
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	
1.1.10		-	
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	11,735,761,109.53	13,274,478,922.25
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	
1.2.1	Үндсэн хөрөнгө	37,946,768.16	122,189,542.76
1.2.2	Биет бус хөрөнгө	7,131,299.04	5,390,625.82
1.2.3	Биологийн хөрөнгө	-	
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	153,026,438.64	300,174,335,883.64
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	
1.2.9		-	
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	198,104,505.84	300,301,916,052.22
1.3	Нийт хөрөнгийн дүн	11,933,865,615.37	313,576,394,974.47
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	9,424,587.60	941,843,593.73
2.1.1.2	Цалингийн өглөг	16,000,492.90	833,848.41
2.1.1.3	Татварын өр	36,563,477.24	72,382,430.39
2.1.1.4	НДШ - ийн өглөг	8,500,867.13	
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	
2.1.1.6	Хүүний өглөг	-	
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	3,100,000,000.00	2,300,000,000.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	17,820.00	
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	
2.1.1.12		-	

Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,170,507,244.87	3,315,059,872.53
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	
2.1.2.5		-	
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,170,507,244.87	3,315,059,872.53
	ЭЗДИЙН ӨМЧ	-	
2.3	Өмч	-	
2.3.1	-төрийн	9,500,000,000.00	309,500,000,000.00
2.3.2	-хувийн	-	
2.3.3	-хувьцаат	-	
2.3.4	Халаасны хувьцаа	-	
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,182,113,942.92)	(737,628,134.28)
2.3.10	Тайлант үеийн үр дүн	445,472,313.42	1,500,174,854.00
2.3.11	Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох	-	
2.3.12	Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	-	
2.3.13	Эздийн өмчийн дүн	8,763,358,370.50	310,262,546,719.72
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	11,933,865,615.37	313,576,394,974.47

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөг/

№	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үйл ажиллагааны орлого	468,010,278.85	23,216,059,034.13
1.1	Брокер, дилерийн үйл ажиллагаа		
1.2	Андеррайтерийн үйл ажиллагааны орлого		
1.3	Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	468,010,278.85	23,216,059,034.13
1.4	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн цэвэр орлого		
2	Түрээсийн орлого	-	
3	Хүүний орлого	873,142,386.28	817,727,885.20
4	Ногдол ашгийн орлого	-	
4.1	Хувьцааны ногдол ашиг	-	
4.2	Хараат болон хамтарсан компаниас олсон ашиг	-	
5	Эрхийн шимтгэлийн орлого	-	
6	Бусад орлого	1,019,234.47	800,277,537.43
7	Борлуулалт, маркетингийн зардал	-	
8	Ерөнхий ба удирдлагын зардал	808,850,683.80	1,362,410,115.54
9	Санхүүгийн зардал	-	21,863,013,698.63
10	Бусад зардал		
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	
13	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	
14	Бусад ашиг (алдагдал)	(723,100.00)	
15	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	532,598,115.80	1,608,640,642.59
16	Орлогын татварын зардал	87,125,802.38	108,465,788.59
17	Татварын дараах ашиг (алдагдал)	445,472,313.42	1,500,174,854.00
18	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	
19	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	445,472,313.42	1,500,174,854.00
20	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	
	Бусад олз (гарз)	-	
21	Орлогын нийт дүн	445,472,313.42	1,500,174,854.00
22	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,500,000,000.00						(1,182,113,942.92)	8,317,886,057.
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
Залруулсан үлдэгдэл	9,500,000,000.00						1,182,113,942.92)	8,317,886,057
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)							445,472,313.42	445,472,313
Бусад дэлгэрэнгүй орлого								
Өмчид гарсан өөрчлөлт								
Зарласан ногдол ашиг								
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,500,000,000.00						(736,641,629.50)	8,763,358,370.
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							(986,504.78)	(986,504.

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,190,349,478.38	323,956,526,002.74
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	49,111,893.15	
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	1,301,052,347.36	23,174,165,314.28
	Хүлээн авсан хүүний орлого	738,353,595.78	769,529,387.93
	Хүлээн авсан ногдол ашиг		
	Бусад мөнгөн орлого	2,101,831,642.09	300,012,831,300.53
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,119,265,457.64	325,377,286,652.12
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	150,300,400.00	303,106,853,306.90
	Ажиллагчдад төлсөн	278,846,031.00	534,379,582.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	81,035,591.92	152,975,194.39
	Бараа материал худалдан авахад төлсөн		68,050.00
	Ашиглалтын зардалд төлсөн		9,306,444.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
	Хүүний төлбөрт төлсөн	80,953.84	
	Татварын байгууллагад төлсөн	25,065,228.53	54,653,315.53
	Даатгалын төлбөрт төлсөн		1,350,000.00
	Зохицуулалтын хөлс, шимтгэл, хураамжид төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	1,583,937,252.35	21,533,000,758.30
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,213,945,220.74	(1,420,760,649.38)
2.	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(7,439,200.00)	(113,030,042.00)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,439,200.00	113,030,042.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		

Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,439,200.00)	(113,030,042.00)
3.	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
	Бусад мөнгөн орлого		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
	Бусад мөнгөн зарлага		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4.	Валютын ханшийн зөрүү		
5.	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,063,644,820.74	(1,533,790,691.38)
6.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,918,183,934.70	10,981,828,755.44
7.	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,981,828,755.44	9,448,038,064.06

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

№	Зардлын зүйл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	1,788,210.4	23,952,701.9	(22,164,491.5)	1,339.48
2	УРСГАЛ ЗАРДАЛ	1,788,210.4	23,952,701.9	(22,164,491.5)	1,339.48
3	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,788,210.4	23,952,701.9	(22,164,491.5)	1,339.48
4	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	867,321.8	594,071.8	273,250.0	68.49
5	Үндсэн цалин	645,465.0	470,844.9	174,620.1	72.95
6	Нэмэгдэл/ KPI	149,676.8	72,903.1	76,773.7	48.71
7	Урамшуулал	59,580.0	40,500.0	19,080.0	67.98
8	Гэрээт ажлын цалин	12,600.0	9,823.8	2,776.2	77.97
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 12.5%	108,415.2	68,187.4	40,227.8	62.89
10	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	315,140.0	263,068.1	52,071.9	83.48
11	Байрны түрээс	204,000.0	184,048.3	19,951.7	90.22
12	Менежмент ашиглалт	9,900.0	9,474.6	425.4	95.70
13	Харуул хамгаалалт	990.0	990.0	-	100.00
14	Урсгал засвар	100,250.0	68,555.2	31,694.8	68.38
15	Харилцаа холбоо, интернэт	6,000.0	2,751.6	3,248.4	45.86
16	Шуудан илгээмж	1,200.0	364.8	835.2	30.40
17	Интернэт, утас	4,800.0	2,386.8	2,413.2	49.73
18	Үйл ажиллагааны зардал	131,500.0	86,887.4	44,612.6	66.07
19	Сургалтын зардал	33,550.0	16,134.8	17,415.2	48.09
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын зардал	43,000.0	26,708.5	16,291.5	62.11
21	Зохицуулалтын хөлс, шимтгэл, хураамж /MASD, FRC, TOC/	12,500.0	5,239.2	7,260.8	41.91
22	Маркетинг, зар сурталчилгаа	7,500.0	4,336.3	3,163.7	57.82
23	Мэдээлэл технологийн үйлчилгээ /outlook/	15,000.0	14,840.0	160.0	98.93
24	Даатгалын зардал	1,850.0	1,850.0	-	100.00
25	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	15,000.0	14,737.6	262.4	98.25
26	Төлбөр хураамжийн зардал	2,000.0	1,988.0	12.0	99.40
27	Бусад зардал	1,100.0	1,053.0	47.0	95.73
28	Хангамж, бараа материал, урсгал засварын зардал	55,000.0	50,721.8	4,278.2	92.22
29	Бичиг хэрэг	11,700.0	9,968.4	1,731.6	85.20
30	Хангамж бараа материалын зардал	14,400.0	14,187.4	212.6	98.52
31	Тээврийн зардал	13,000.0	12,333.0	667.0	94.87
32	Цэвэрлэгээ үйлчилгээний	5,400.0	5,355.0	45.0	99.17
33	Урсгал засварын зардал	2,500.0	2,500.0	-	100.00
34	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,000.0	6,378.0	1,622.0	79.73
35	Хөрөнгө худалдан авах зардал	115,899.8	97,730.0	18,169.8	84.32

Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

36	Томилолт, зочны зардал	84,833.6	13,514.5	71,319.1	15.93
37	Гадаад томилолт	71,333.6	5,994.5	65,339.1	8.40
38	Зочин төлөөлөгч хүлээн авах	13,500.0	7,520.0	5,980.0	55.70
39	ТУЗ холбоотой зардлууд	104,100.0	70,193.1	33,906.9	67.43
40	ТУЗ цалин	79,200.0	55,791.3	23,408.7	70.44
41	ТУЗ НДШ зардал	9,900.0	4,708.1	5,191.9	47.56
42	Хурлын зардал	15,000.0	9,693.7	5,306.3	64.62
43	4 САНГИЙН ЗАРДАЛ	-	22,705,576.3	(842,562.6)	-
44	Кастидионы төлбөр		159,469.5	(159,469.5)	-
45	ХОМК менежмент үйлчилгээний шимтгэл		669,593.1	(669,593.1)	-
46	Бондын хүүгийн зардал		21,863,013.7	(21,863,013.7)	-
47	Аудит төлбөр		13,500.0	(13,500.0)	-
48	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,791,250.0	25,503,657.5	(23,712,407.5)	1,423.79
49	Сангийн менежментийн үйлчилгээнээс санхүүжих	963,250.0	669,593.1	293,656.9	69.51
50	Хадгаламжийн хүүгээс санхүүжих	828,000.0	817,727.9	10,272.1	98.76
51	Үнэт цаасны арилжааны цэвэр орлого		23,216,059.0	(23,216,059.0)	-
52	Борлуулалтын орлого		800,277.5	(800,277.5)	-
53	АШИГ/алдагдал	3,039.6	1,550,955.6		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн эрхэм зорилгоо “Улаанбаатар хотын тогтвортой хөгжил, хариуцлагатай хөрөнгө оруулалтыг цогцлоох”-д оршино гэж тодорхойлжээ.

Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК нь Нийслэл Улаанбаатар хотын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын салбарт үйл ажиллагаа явуулах, үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн харьяа байгууллага юм.

Тус компанийн 7 төрлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх чиглэлтэй. Үүнд

1. Хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх;
2. Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа;
3. Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах;
4. Үнэт цаасыг итгэмжлэн удирдах;
5. Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах;
6. Даатгалын компанийн нөөц хөрөнгийг итгэмжлэн удирдах;
7. Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ;

Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК нь итгэмжлэн удирдаж буй 4 хувийн хөрөнгө оруулалтын сантай үйл ажиллагааг өргөжүүлэн Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн нийгэм, эдийн засгийн үр өгөөжтэй дунд болон урт хугацаанд хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийх мөн удирдаж буй хөрөнгө оруулалтын сангуудад дотоод гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, засаглалын зохистой тогтолцоог хэвшүүлэн ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө оруулалтын санд холбогдох үйлчилгээг үзүүлэхдээ тухайн сангийн гишүүдийн эрх ашгийн төлөө, сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус үйл ажиллагаа явуулах үүрэгтэй. Үүнд:

1. “Нийслэлийн хөгжлийн сан хувийн ХОС ТЗК” ХХК нь 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Хөрөнгө оруулалт нь авто тээвэр, эрчим хүч, барилга, дэд бүтэц, аж үйлдвэр гэсэн үйл ажиллагаа явуулах чиглэлээр.
2. “Нийслэлийн гарааны бизнесийг дэмжих сан хувийн ХОС ТЗК” ХХК нь 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Хөрөнгө оруулалт нь мэдээлэл технологи, боловсрол, тээвэр логистик, инновац, эрүүл мэнд гэсэн үйл ажиллагаа явуулах чиглэлээр.
3. “Нийслэлийн ногоон хувийн ХОС ТЗК” ХХК нь 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Хөрөнгө оруулалт нь ногоон эдийн засгийг дэмжих, орчны бохирдол бууруулах, ногоон ажлын байр бий болгох, Экосистемийг бий болгох, Хүлэмжийн хийг бууруулах гэсэн үйл ажиллагаа явуулах чиглэлээр.
4. “Нийслэлийн эрсдэлийн удирдлагын сан хувийн ХОС ТЗК” ХХК нь 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Хөрөнгө оруулалт нь уул

уурхай, хөдөө аж ахуй, ойн аж ахуй загас барилт, ан агнуур, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, боловсрол, боловсруулах үйлдвэр, цахилгаан, хий уур, агааржуулалт, усан хангамж, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, эрүүл мэнд, барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, үйлчилгээ гэсэн үйл ажиллагаа явуулах чиглэлтэй үйл ажиллагааг явуулж байна.

3.2 Компани /ТӨҮГ/-ын гадаад, дотоод орчин

Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 179 дугаар тогтоол, 2019 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн 72 дугаар тогтоолоор үүсгэн байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК нь 100 хувь нийслэлийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай ҮЦК бөгөөд хувьцаа эзэмшигч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байна.

Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журам, Нийслэл Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамж, болон бусад холбогдох хууль тогтоомж, ТУЗ-ийн тогтоолыг мөрдлөг болгон ажилладаг.

Тайлант хугацаанд Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын тухай хууль,
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 05/03 дугаартай “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн бүтэц орон тоо, цалин, хөлсний дээд хязгаар, шатлалыг шинэчлэн батлах тухай.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК нь төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дүгээр сарын 29-ны өдрийн 01/02 тоот Дотоод хяналт, эрсдэлийн албаны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 5

зорилт, 27 арга хэмжээ баталж гүйцэтгэлээр 7 зорилт 20 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж 95.2 хувийн биелэлтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг 2024 онд өөрчлөлт оруулан мөрдөж ажиллаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2017 оны 221/331 хамтарсан тушаалаар батлагдсан “Үнэт цаасны зах дээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын дагуу санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 313,578,679.7 мянган төгрөг болж өмнөх оноос 301,644,814.1 мянган төгрөгөөр өссөн нь эзэмшигчийн өмч нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,981,828.7	9,448,038.1	(1,533,790.6)
Авлага	228,574.4	1,374,298.0	1,145,723.6
Бусад санхүүгийн хөрөнгө	500,000.0	2,450,000.0	1,950,000.0
Урьдчилж гарсан зардал			-
Бараа материал	25,357.9	4,427.6	(20,930.3)
Үндсэн хөрөнгө	37,946.7	122,189.5	84,242.8
Биет бус хөрөнгө	7,131.3	5,390.6	(1,740.7)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	153,026.4	300,174,335.9	300,021,309.5
Нийт хөрөнгө	11,933,865.6	313,578,679.7	301,644,814.1
Өр төлбөр	3,170,507.2	3,315,104.6	144,597.4
Эздийн өмч	9,500,000.0	309,500,000.0	300,000,000.0
Хуримтлагдсан ашиг	(736,641.6)	763,575.1	1,500,216.7
Эздийн өмчийн дүн	8,763,358.4	310,263,575.1	301,500,216.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,933,865.6	313,578,679.7	301,644,814.1

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 9,448,038.1 мянган төгрөг болж өмнөх оноос 1,533,790.6 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгө оруулалт, бонд худалдаж авснаас шалтгаалсан бөгөөд сангийн харилцах данс 1,288,000.0 мянган төгрөг, хадгаламж 7,284.347.1 мянган төгрөг, харилцах дансны үлдэгдэл 875,690.9 мянган төгрөг тус тус банкинд байршиж байна. Өмнөх оны Үндэсний хөрөнгө оруулалтын банканд их хэмжээний хэлцэл болох хадгаламжийн гэрээ байгуулж 2.0 тэрбум төгрөг хадгалуулсан албан шаардлага өгсөн. Тус байгууллагаас 2024 онд ҮХОБ-нд хадгаламжийн мөнгөө татан авах тухай мэдэгдэл, болон албан шаардлага 5 удаа бичгээр хүргүүлсэн боловч дорвитой арга хэмжээ авахгүй байсан учир 2024 оны 12 сарын 02-ны өдрийн А/126 тоот НӨУБХОМК ҮЦК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар 2 талаас ажлын хэсэг байгуулж ҮХОБ-тай эвлэрлийн гэрээг 2025 оны 02 сарын 24-ны өдөр байгуулсан байна

Авлага дансны үлдэгдэл тайлант онд 1,374,298.0 мянган төгрөг болж өмнөх оноос 1,145,723.6 мянган төгрөгөөр өссөн Нийслэлийн хөгжлийн сангийн Бөөрөлжүүтээс авах бондын хуримтлуулан тооцсон хүүгийн авлага 843,473.4 мянган төгрөг, нийслэлийн гарааны бизнесийн сангийн Инвескор Капитал ҮЦК МИК бондын хуримтлагдсан хүү 10,554.8 мянган төгрөг, Эрсдэлийн удирдлагын сангийн МИК бондын хуримтлагдсан хүү 28,288.3 төгрөгийн хуримтлуулан тооцсон хүүгийн авлагаас шалтгаалсан байна.

Бусад санхүүгийн хөрөнгө тайлант онд 2,450,000.0 мянган төгрөг болж өмнөх оноос 1,950,000.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлангийн хугацаанд 5 нэр төрлийн бондоос 13,700 ширхэг 2,571,310.9 мянган төгрөгийн бонд худалдан авч 47,437 ширхэг 621,310.9 мянган төгрөгийн бондыг арилжсанаас шалтгаалсан байна.

Бараа материалын данс 4,427.6 мянган төгрөг болж өмнөх оноос 20,930.3 мянган төгрөгөөр буурсан нь ашиглалтад байсан хангамжийн материал, бичиг хэрэг, сургалтын материал зэрэг байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэсэн материалын зарцуулалтаас шалтгаалсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл тайлант онд 122,189.5 мянган төгрөг болж өмнөх оноос 84,242.8 мянган төгрөгөөр өссөн нь тоног төхөөрөмж 55,963.7 мянган төгрөг 41,766.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, тайлант онд 13,487.2 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалсан байна.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 5,390.6 мянган төгрөг болж 1,740.7 мянган төгрөгөөр буурсан нь тухайн жилд байгуулсан хуримтлагдсан элэгдлээр буурсан байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 300,174,335.9 мянган төгрөг болж өмнөх оноос 300,000,000.0 мянган төгрөгөөр өссөн нь 3 жилийн хугацаатай 3,000 ширхэг, 100,000.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий жилийн 14.44%-ийн хүүтэй хаалттай бонд худалдан авч хөрөнгө оруулснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл тайлант жилд 3,170,507.2 мянган төгрөг болж өмнөх оноос 42,518.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны аж ахуй нэгжийн албан татварын өглөгөөс шалтгаалсан байна.

Засгийн газрын өмч дансны үлдэгдэл тайлант онд 309,500,000.0 мянган төгрөг болж өмнөх оноос 300,000,000.0 мянган төгрөгөөр өссөн нь Нийслэлийн засаг даргын тамгын газар нь бөөрөлжүүтийн бондод хөрөнгө оруулалт хийхээр дүрмийн санг нэмэгдүүлсэнтэй холбоотой

Хуримтлагдсан алдагдал дансны үлдэгдэл тайлант онд 763,575.1 мянган төгрөг болж өмнөх оноос 1,500,216.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны цэвэр ашгаас шалтгаалсан бөгөөд өмнөх оны хуримтлагдсан ашиг/ алдагдал дансанд 2019 оны татварын тооцооллыг буруу хийснээс үүссэн 986.5 мянган төгрөгийн залруулга хийсэн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн дагуу ажил үйлчилгээ, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 01/03 дугаар тогтоолоор 1-р хавсралтаар 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,362,825.8 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,362,825.8 мянган төгрөгөөр татварын өмнөх 2,924.2 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 142,499.8 мянган төгрөгийг төлөвлөсөн байна. Мөн үйл ажиллагаа өргөжиж Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 10-р сарын 23-ны өдрийн 05/04 дугаар тогтоолоор компанийн 2024 оны төсвийн тодотгол, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж тайлант оны нийт орлогыг 1,791,250.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,788,210.4 мянган төгрөг, 3.039.6 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 2,287,598.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,202,894.0 мянган төгрөгийн зардал гаргаж 1,084,704.4 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2,287,598.51 мянган төгрөг болж төлөвлөснөөс 496,348.51 мянган төгрөг буюу 27.71 хувиар давсан нь сангийн менежментийн үйлчилгээний орлого 265,665.1 мянган төгрөг, хадгаламжийн хүүгийн орлого 202,452.4 мянган төгрөгөөр давснаас шалтгаалжээ

Нийт зардлын гүйцэтгэл 1,247,125.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 541,084.8 мянган төгрөг буюу 30.26 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь сангийн үйл ажиллагаанууд жигдрээгүй, орон тоо 9 хүнээр дутуу ажилласантай холбоотой цалингийн зардал 273,250.0 мянган төгрөг, НДШ 40,227.8 мянган төгрөг, шуудан холбооны зардал 3,248.4 мянган төгрөг, үйл ажиллагааны зардал 44,612.6 мянган төгрөг, хангамжийн материал 4,278.2 мянган төгрөг, хөрөнгө худалдан авах зардал 18,169.8 мянган төгрөг, томилолтын зардал 71,319.1 мянган төгрөг, ТУЗ-тэй холбоотой зардлууд 33,906.9 мянган төгрөгийн зардлуудыг хэмнэсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 1,550,955.6 мянган төгрөгт хүрч төлөвлөснөөс 1,547,916.0 мянган төгрөгөөр ашигтай ажилласан нь бондын хүүгийн орлогоос шалтгаалсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн өр өгөөж өгөх хөрөнгийг дахин үнэлүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Си Эс Ай Аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Чулуунбат, аудитор Б.Отгончимэг, С.Цэнд-Аюуш, Г.Должинсүрэн нар гүйцэтгэж чанарын хяналтын менежер С.Содномцэрэн, компанийн захирал М.Сэвжидмаа нар анхан шатны чанарын хяналтыг, Нийслэл дэх төрийн аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр, дэд дарга Ч.Болд нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК санхүүгийн тайлангаа Нийслэл дэх төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 896,699.6 мянган 1.0 хувиар буюу 8,967.0 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага болон дээд шатны төсвийн захирагчаас төрийн хэмнэлттэй холбоотой тушаал шийдвэр гарах, арга хэмжээ авах нөхцөл байдал үүсээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулбал зохих 157 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, нийт 1,788,210.0 мянган төгрөгийн 149 мэдээг мэдээлсэн, 2 мэдээлэл мэдээллээгүй хугацаа хоцроосон 6 мэдээлэл байна. Мэдээлсэн байдлын хэрэгжилт 98.3 хувь, хугацаа хоцролт 96.4 хувь байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 5.5.Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна” гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хугацаанд нь шилэн дансны цахим системд бүрэн тайлагнаж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг үзэхэд худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил илрээгүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны III дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, нийт зардлын дансны хувьд горим, сорил хэрэгжүүлж, нийт 1,412.8 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илрүүлж, залруулга хийх талаар шалгагдагч байгууллагад асуудлын бүртгэлээр танилцуулан, баталгаажуулж, 1,412.8 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон 7,848,964.5 мянган төгрөгийн 6 зөрчилд 7,848,964.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 3 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Албан шаардлага	3	7,848,964.5	3	7,848,964.5	100.0
Зөвлөмж	3	-	3	-	100.0
Нийт дүн	6	7,848,964.5	6	7,848,964.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бондын худалдан авалт, эргэн төлөлт, гэрээний хэрэгжилтийг хянах, үр өгөөж, нягтлан бодох бүртгэлийн бодолго нь үнэт цаасны журам, санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан хууль эрх зүйн актад нийцэж байгаа эсэхийг анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,371.4 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад 2,371.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Тус байгууллагын авлагын дансны үлдэгдлийг тулган шалгахад 2019-онд ажиллагсдын нэр дээр үүссэн 2,284.8 мянган төгрөгийн авлага эзэн холбогдогчгүй данс бүртгэлд бүртгэлтэй байна.
- Тус байгууллагын өглөгийн дансны үлдэгдлийг тулган шалгахад 2019-онд үүссэн ажиллагсдын нэр дээр үүссэн 86.6 мянган төгрөгийн өглөг эзэн холбогдогчгүй данс бүртгэлд бүртгэлтэй байна.

Аудитаар 1 зөрчил² илэрснээс, аудитаар 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 8,967.0 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой эдийн засгийн үр өгөөж хүртгэж буй 2,209.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй 2 нэр төрлийн үндсэн хөрөнгийг дахин үнэлүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "хэмжигдэхүйц байх"; Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолын 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг тус тус нийцэхгүй байна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлүүлэх, зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 31-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тус байгууллагын авлагын дансны үлдэгдлийг тулган шалгахад 2019- онд ажиллагсдын нэр дээр үүссэн 2,284.8 мянган төгрөгийн авлага эзэн холбогдогчгүй данс бүртгэлд бүртгэлтэй байна.	1	2,284.8			1	2,284.8	1	2,284.8				
Тус байгууллагын өглөгийн дансны үлдэгдлийг тулган шалгахад 2019- онд үүссэн ажиллагсдын нэр дээр үүссэн 86.6 мянган төгрөгийн өглөг эзэн холбогдогчгүй данс бүртгэлд бүртгэлтэй байна.	1	86.60			1	86.60	1	86.60				
Дүн	2	2,371.4			2	2,371.4	2	2,371.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	тоо	дүн			тоо	дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		тоо	дүн
							тоо	дүн	тоо	дүн		
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой эдийн засгийн үр өгөөж хүртгэж буй 2,209.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй 2 нэр	1	-					1	-				

Нийслэлийн өмчит Улаанбаатар Хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-ийн
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

төрлийн үндсэн хөрөнгийг дахин үнэлүүлээгүй байна.												
Дүн	1	-				1	-					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг.

Зөрчлийн төвч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллага нь тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих 157 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, нийт 1,788,210.0 мянган төгрөгийн 149 мэдээг мэдээлсэн, 2 мэдээлэл мэдээллээгүй хугацаа хоцроосон 6 мэдээлэл байна. Мэдээлсэн байдлын хэрэгжилт 98.3 хувь, хугацаа хоцролт 96.4 хувь байна.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт Дүн	1	-					1	-